

10

АЖ АХУЙН НЭГЖИЙН ШИНЭЧЛЭЛ- ЭДИЙН ЗАСГИЙН
ӨӨРЧЛӨН БАЙГУУЛАЛТЫН ҮНДЭС МӨН

Д.Цэрэнпил

Эдийн засгийн макро, микро түвшний харилцан холбоо

Эдийн засаг макро, микро түвшний тогтолцоог өөртөө агуулж байдаг. Макро түвшин улс орны хэмжээнд гарч байгаа нийт эдийн засгийн өсөлт, бууралт, инфляци, ажил эрхлэлтийн өөрчлөлт, санхүү, мөнгө-зээлийн үйл явц, хөрөнгө оруулалтын идэвхжил зэргийг тусган харуулна. Микро түвшинд хаана үйлдвэр, байгууллага, өрхийн аж ахуй-аж ахуйг эрхлэх субъектүүд үйл ажиллагаа явуулдаг. Тэднийг улс орны нийгэм-эдийн засгийн хөгжлийн гагцхүү тодорхойлох хүчин зүйл болох зонхилох салбарын үүднээс бүхэлд нь авч үздэг. Эдгээр түвшин хоорондын янз бүрийн чиглэлээр хүчтэй өгсөх, уруудах үйл ажиллагаа, "налуугийн" холбоог бодолцохгүйгээр бүхэл эдийн засгийн байдлыг тайлбарлах, эдийн засгийн бодлогыг боловсруулах, хэрэгжүүлэх боломжгүй юм.

Эдийн засгийн хямрал, өсөлтийн аль ч нөхцөлд нэг түвшинд хэрэгжүүлж байгаа өөрчлөлт нөгөө түвшиндээ заавал тусгалаа олж байдаг нь манай оронд сүүлийн арав гаруй жилд хийгдсэн шинэчлэлээс тодорхой.

Жишээлбэл, макро түвшинд мөнгө-зээлийн бодлогыг хатууруулахад микро түвшин бартерын худалдааг өргөтгөж, бүх аж ахуйн нэгжийн төлбөрийн чадвар муудаж, зээлийн өндөр хүү, өрийн дарамтад орж байсан үе 1991-1996 оны хооронд манайд гарч байсан.

Эдийн засгийн бүтцийн зохион байгуулалтыг авч үзэхэд түвшин хоорондын холбоо улам нягт гарч ирдэг. Нийгэм-эдийн засгийн бүтэц олон түвшний шинж чанартай бөгөөд нэг түвшиндээ цаашид баримжаалж, бусад нь түүнийг дагаж хөгждөг жамтай. Иймээс эдийн засгийн бүх түвшинд чиглэл зорилготой зохицуулагдсан үйл ажиллагаа, тохирсон механизм зайлшгүй, энэ нь тодорхой хууль тогтоомж, норм, журмаар баталгаажсан байна. Энэ нь Монгол улс зах зээлийн эдийн засагт шилжих, шинэчлэл явуулахад нийгмийн

нормыг дэлгэрүүлэх, бэхжүүлэхийн тул түвшин хоорондын харилцан үйлчлэлийг хангах чадвар бүхий төрийн бүтээлч оролцоо нь шинэчлэлийг зохицуулах ганц хүч болсноор тайлбарлагдана.

Үүний зэрэгцээ нийгмийн хөгжлийн тодорхой үе шатанд эдийн засгийн динамикийн хүчин зүйлд шийдвэрлэх роль нь чухамдаа аль нэгэн түвшинд хамаарагддаг. Өнөөгийн шатанд Монголын эдийн засгийн хөгжлийн үндсийг тодорхойлогч тийм түвшин нь микро эдийн засаг өөрөөр хэлбэл бодит эдийн засгийн салбарууд бүр тодруулбал аж ахуйн нэгжүүдийн удирдлагын түвшин болно.

Үүний гол шалтгаан нь эдийн засгийн зохион байгуулалт-удирдлагын тогтсон бүтэц юм. Шилжилтийн арав гаруй жилд манай эдийн засагт зохион байгуулалтын эрс өөрчлөлт гарсан, хэсэг хугацаанд аж ахуйн нэгж хоорондын болон бусад байгууллага, субъектийн зохион байгуулалтын холбоо эвдэрсэн. Эдийн засгийн салбарын бүтэц ихээхэн задарсан явдал нэг гол анхаарах зүйл мөн.

Макро түвшинд янз бүрийн хүчний нөлөөн дор гүйцэтгэх засаглал, сонголтын байгууллагын төдийлэн сайн боловсрогдож бодогдоогүй бүтэц, төрийн удирдлагын бүтээлч чиглэмж доогуур түвшинд байсан, мөн удирдлагын хуучин, шинэ тогтолцооны зөрчил ямар нэг хэмжээгээр байлаа.

Микро түвшний объект-үйлдвэр, аж ахуйн нэгжүүд хэвээр боловч зохион байгуулалтын нааштай өөрчлөлт дэлгэрч үйлдвэрлэлийн хүрээнд зах зээлийн эдийн засагт зохицон хувьсах үйл явц хурдацтай явагдсан. Үүнэндээ энэ л объектоор дамжин "шинэчлэлийн хүрд" үр ашигтай, стратегийн чиг баримтлалтай, ардчилсан эдийн засгийг бий болгоход гол хүчээ чиглүүлнэ. Аж ахуйн нэгжүүд нь зөвхөн бүтээгдэхүүний үйлдвэрлэл, борлуулалтын өсөлтийн хурдыг хангахуйц "өсөлтийн үүргийн цэг" төдийгүй эдийн засгийн болон санхүү, мөнгө-зээлийн секторын дэвшилт өөрчлөлтийг хэрэгжүүлэх, дэмжих болон шинэчлэлийн гарааны эхлэл "удирдлага, зохион байгуулалтын өсөлтийн цэг" болох ёстой. Аж ахуйн нэгжийн шинэчлэлээр дамжин эдийн засгийн шинэчлэлийн зам гарна.

Аж ахуйн нэгж, эдийн засгийн шинэчлэл

Аж ахуйн нэгжийн үйл ажиллагааны үр ашиг дорой байдал нь эдийн засгийн өөрчлөн байгуулалтын тодорхойлогч чиглэлд гол утга санаа боллоо. Захиргаадал-командлалын тогтолцооны далайлт дор үйлдвэр, аж ахуйн нэгжүүдийн боломж хэрэгжихгүй, нөөцийн ашиглалт үр ашиггүй байлаа. Шилжилтийн эхнээс эдийн засгийг өөд татах тулгуур элемент бол үйлдвэрлэгч аж ахуйн нэгж мөн гэж үзэж байв. Материаллаг баялгийг үйлдвэрлэгч нэгж-аж ахуйн нэгжүүд нь хүчтэй үйлдвэрлэх хүч болохыг нээн илрүүлэх явдал өнөө үеийн нэгэн гол тулгамдсан асуудал.

Шилжилтийн үеийн макро эдийн засгийн орчинд авч буй арга хэмжээ, шийдвэрлэгдэж байгаа асуудлууд нь аж ахуйн нэгжүүдийн өөрөө өөрчлөн байгуулагдах нөхцлийг бүрдүүлж байна.

Макро эдийн засгийн өөрчлөлтийн үр дүн төр, засгийн болон нийгмийн анхаарлын тэргүүн эгнээнд байсан, харин аж ахуйн нэгж нь энэ шинэчлэлийн

зохион байгуулалтын объект болж байв. Шилжилтийн эхэн үед аж ахуйн дийлэнх нэгжүүд, улмаар боловсруулах үйлдвэрлэлийн салбарын уналт удаан үргэлжилсэн. Эдийн засгийн ардчиллын нөхцөлд ажиллаж байгаа аж ахуйн нэгжүүдэд үйлдвэрлэх хүчний хөгжил төдийлэн олигтой дэвшилд хүрч чадаагүй. Өмнөх тогтолцооноос уламжлагдсан макро эдийн засгийн олон асуудал (хуучирсан технологи, шинэ сэдэлтийн сул эрэлт, элэгдэж хуучирсан техник зэрэг) нь нэлээд шинэ сөрөг үр дагаврыг цогцолбор, чиглэл зорилтот удирдлага, чанарын бууралт; аж ахуйн нэгж дээр нөхөн шийдвэрлэлийн үйл явцыг саатуулахад хүргэсэн, хөгжлийн үргэлжлэлд хохирол учруулсан богино хугацааны зорилго; өмчлөгч, ажиллагчид, удирдлагын хооронд нийгмийн ачааллын өсөлт; өндөр мэргэжлийн боловсон хүчний алдагдал зэргийг учруулж байна. Аж ахуйн нэгжид зохион байгуулалтын бүтцийн орчин алдагдаж, санхүүгийн чадвар доройтох нь нийгэм-эдийн засгийн "агаар"-ын гүнзгий дутагдалд оруулж, тэднийг элсэн дээр хаягдсан загас шиг болгосон. Үнэндээ манай ихэнх аж ахуйн нэгжүүд санхүүгийн туйлын хүнд байдалд орсон.

Эдийн засгийг ардчилах үзэл бодлын эцсийн үр дүн нь олон хязгаарлалт, хомсдлыг учруулсан төрийн хатуу нөлөөллөөс аж ахуйн хүрээг чөлөөлж, зах зээлийн эдийн засгийн шинэ бүтцийг бүрдүүлэхэд оршино.

Эдийн засгийн нэг хэв шинжээс нөгөөд шилжих нь А байрнаас Б байрлуу биет нүүлгэлт хийхтэй огт адилгүй, үндэсний эдийн засгийн онцлог оюуны болон техникийн хуримтлагдсан чадавхийг ашиглах суурь дээр шинэ эдийн засгийн элементүүдийг төлөвшүүлж байгаа төвөгтэй өөрчлөн байгуулалт. Энэ нь зөвхөн аж ахуйн нэгжид шинэчлэл хийх үндсэн дээр боломжтой.

Аж ахуйн нэгжийн шинэчлэлийн үндсэн чиглэлийг тодорхойлохын тулд улс орныхоо орчин үеийн эдийн засагт аж ахуйн нэгжийн үйл ажиллагааны болон бүтцийн рольд үнэлгээ өгөх ёстой.

Эдийн засгийн зүтгэх хүч-үйлдвэрлэлийн аж ахуйн нэгж

Монгол улсад 1990 оны 1800 аж ахуйн нэгжтэй байсан, 2002 онд жилийн эцсийн татварын тайлангаар үзвэл 27000 шахам болж олширчээ. Үүний дотор хувиараа эрхлэх аж ахуй 3188, хоршоо 2267, нөхөрлөл 3559, хувьцаат компани 407, хязгаарлагдмал хариуцлагатай компани 17173 байна.

Орчин үеийн нөхцөлд үйлдвэржсэн эдийн засгийн үйл ажиллагааны бүтцийг бүрдүүлэгч нь үйлдвэрлэл, үйлчилгээний аж ахуйн нэгжүүд юм. Зах зээлийн голидролоор өөрчлөн шинэчлэгдсэн аж ахуйн нэгжүүд нь нийгэм, эдийн засаг, захиргааны өргөн хүрээтэй субъектүүд: аж ахуйн нэгжийн ажиллагсад, түнш-аж ахуйн нэгж, хэрэглэгчид, хөрөнгө оруулагчид, санхүү-зээлийн байгууллага, төв, орон нутгийн удирдах байгууллага болон бусад холбоо харилцаа бүхий нийгэм-эдийн засгийн үйл ажиллагааны өвөрмөц зүтгэх хүчний ролийг гүйцэтгэнэ. Аж ахуйн нэгжүүд зөвхөн зүтгэх үйл ажиллагаа төдийгүй бусад үүрэгтэй:

- Эдийн засгийн бүрэлдэхүүний хязгаарлагдмал хөдлөлийг хөгжлийн ойрын ба хэтийн чиг баримтлалын дагуу чиглүүлж, тогтворжуулах (бүтцийн өөрчлөлт, шинэчлэлт);

- Нийгмийн хэмжээнд болон салбар, аж ахуйн нэгжийн хүрээнд өргөтгөсөн нөхөн үйлдвэрлэлийн зорилт, чиглэлийг шинэчилж, үүний дагуу хуримтлал хэрэглээний бүтцийг өөрчлөх;
- Бүс нутгийн болон салбарын байршлын хооронд үйлдвэрлэгч, хэрэглэгчдийн хооронд, эдийн засгийн макро, микро түвшний дэд бүтцийн хоорондын эдийн засгийн харилцааны гол субъект болж интеграцийн үүргийг гүйцэтгэнэ.

Аж ахуйн нэгжүүдийн үүрэг, роль шавхагдашгүй. Иймээс орчин үеийн эдийн засагт аж ахуйн анхан шатны нэгжийн роль мөн чанарыг ойлгох явдал тодорхой нэгжийн удирдлагаас эхлээд удирдлагын бүх түвшинд микро эдийн засгийн бодлого боловсруулахад нэн чухал ач холбогдолтой.

Аж ахуйн нэгжийн үүргийг тодорхойлох нь зөвхөн онолын төдийгүй, практикийн өргөн утга агуулгатай. Ялангуяа удирдлагын бүх түвшинд эдийн засгийн бодлогыг боловсруулах, хэрэгжүүлэхэд илүү нөлөөтэй.

Аж ахуйн нэгжийн үүргийг шинжиж үзэхэд онолын болон практикийн хоёр хандлага байх боломжтой. Үйлдвэр, аж ахуйн нэгжийн үндсэн үүргийн бүрэлдэхүүн, харилцан холбооны асуудал эдийн засгийн онолд бүрэн шийдэгдээгүй юм. Гэхдээ орчин үеийн эдийн засгийн сэтгэлгээний үндсэн чиглэлээр ямар нэг хэмжээгээр асуудалд хариулт өгөгдсөн.

Эдийн засгийн онолд үйлдвэр, аж ахуйн нэгжийн дараах үүргүүдийг тодорхойлсон:

- үйлдвэрлэлийн үүрэг-хэрэглээнд зориулсан таваарын үйлдвэрлэл
- бүтээгдэхүүний үнэ бүрдүүлэлтийн үүрэг-өөрийн бүтээгдэхүүн ба дайчилсан нөөцийн зардлыг бүртгэж үнэ тогтоох
- эрэлтийн үүрэг-хөдөлмөр, материал, санхүүгийн нөөцийг ашиглах, бүрдүүлэх
- маркетинг-борлуулалтын үүрэг-бүтээгдэхүүнийг хэрэглэгчдэд хүргэх
- үйлдвэрлэлийн үр ашгийн (үр дүнгийн) үүрэг-эцсийн дүнд ашиг, орлогтой ажиллах.

Нийгэм, эдийн засгийн бүхий л харилцааны холбоо уялдааны болон танин мэдэхүйн үүднээс нь авч үзвэл үйлдвэр аж ахуйн нэгжийн үүрэг олон талтай, өргөн сүлжээтэй болж байна.

Аж ахуйн нэгжийн үндсэн үүргүүд

№	Үүргийн нэр	Үүргийн агуулга	Тухайн үүргийг хүлээн авагч
1.	Үйлдвэрлэл	Эдийн засгийн хэрэгцээг хангахын тулд таваар, ажил үйлчилгээний үйлдвэрлэл	Бүтээгдэхүүний бодит буюу чадавхи бүхий хэрэглэгч болох хуулийн этгээд, хувь хүн (хүн ам)
2.	Борлуулалт-маркетинг	Маркетинг ба үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний борлуулалт	чадавхитай, бодит хэрэглэгчид, бодит, чадавх бүхий үйлдвэрлэлийн бүтээгдэхүүн. Тухайн бүтээгдэхүүний зах зээл бүхэлдээ.

3.	Нөөц-эрэлт	Хөдөлмөр, материал, санхүү, мэдээлэл болон оюуны нөөц, технологи, үйлдвэрлэлийн зохион байгуулалтын аргын эрэлт	Түүхий эд материалыг бэлтгэн нийлүүлэгч-үйлдвэр аж ахуйн газар, худалдаа-зуучлалын байгууллага, иргэд. Үйлдвэрлэл дээр ажиллах боловсон хүчнийг бэлтгэх сургалтын байгууллага. Үйлдвэрлэлд өөрийн боловсруулж санаачилсан зүйлийг нэвтрүүлдэг зураг төслийн болон шинжлэх ухаан судалгааны туршилт зохион бүтээх байгууллага. Аж ахуйн нэгжийн чадавх бүх ажиллагчид.
4.	Санхүү-хөрөнгө оруулалт	Зээлжилт, хөрөнгө оруулалт, үнэт цаас гаргах, эзэмших, худалдаа авахтай холбоотой санхүүгийн урсгалын хөдөлгөөн.	Тухайн аж ахуйн нэгжийг зээлжүүлдэг, мөнгөн гүйлгээний үйлчилгээ явуулдаг санхүү-зээлийн байгууллага, ганцаарчилсан болон хамтарсан бүтцийн хөрөнгө оруулагч (хувь нийлүүлэгч)
5.	Төсвийн	Улсын ба орон нутгийн төсвийн орлого хуримтлал	Бүх түвшний төсөв, төсвийн гадуурх сангууд, удирдлагын бүх түвшний байгууллага
6.	Нийгмийн	Холбогдох боловсрол, мэргэжил бүхий иргэдийг ажлаар хангах. Ажиллагсад тэдний гэр бүлийн хөдөлмөрийн чадваргүй гишүүдэд тэтгэмж тусламжаар хангах. Хамтарсан ажлын дадлага туршлагаар хүмүүжүүлэх. Ажиллагсадын хамтын хэрэгцээг хэрэгжүүлэх, хувь хүнд нийгмийн үнэлгээ өгөх.	Үйлдвэр, аж ахуйн нэгжид ажиллагсад, тэтгэвэрт гарсан хүмүүс, үйлдвэрлэлийн удирдах чадавх бүхий ажилтан.
7.	Танин мэдэх, судлах	Таваар, нөөцийн зах зээлийн онцлог үйл ажиллагааны үйл явц, техник, технологийн тогтолцоо, зах зээл, хувь нийлүүлэгчидтэй харилцан үйлчлэх, үйлдвэрлэлийн зохион байгуулалтын үр ашигтай аргыг судлана. Дараачийн залгамж үеийнхэнд холбогдох мэдлэг, мэргэжлийг эзэмшүүлэх, хуримтлуулах	Ажлын дадлага, мэдлэг, туршлага эзэмшиж байгаа тухайн аж ахуйн нэгжийн ажиллагсад. Мэдээлэл, нөөцийн (үүний дотор хөдөлмөрийн шилжих хөдөлгөөнөөр дамжуулан) солилцоогоор дамжуулах, мөн түүнчлэн тухайн аж ахуйн зан үйлийн ажиглалтаар дамжуулан мэдлэг хуримтлуулж, эзэмшигч болж байгаа бусад аж ахуйн нэгжүүд.
8.	Боловсрол	Хамт олон, тусгайлсан ажиллагсадад үйлдвэрлэлийн (тухайлбал: техник-технологийн, эдийн засаг, удирдлагын) ажлын мэдлэг, дадлага, туршлага олгох	Тухайн үйлдвэр дээр олж авсан мэдлэгээ ашиглаж өөр ажилд шилжсэн ажиллагч болон нийт ажиллагсад. Тухайн аж ахуйд ажиллаж байсан ажиллагсадыг үйлдвэрлэлд татан оруулах.
9.	Шинэ санаа-сэдэлт	Түнш ба өрсөлдөөний харилцаатай холбоотой шинэ санаа сэдэлтийг аж ахуйн хамт олны дунд өрнүүлэх, дэлгэрүүлэх, бүртгэх, хадгалах, урамшуулах	Тухайн аж ахуйн нэгжээр дамжуулан (эсвэл тухайн аж ахуйд бий болсон) шинэ санаа сэдэлтийг авч байгаа аж ахуйн нэгж. Шинэ санаа сэдэлтийг дэлгэрүүлэгч ба зохиогчид.

10.	Мэдээлэл-технологи	Нийлүүлэлтийн үнэ, нөхцөл, бүрдүүлэлтийн тусламжтайгаар зах зээлийн сектор, хэсэглэл, эрэлтийн онцлогийн тухай мэдээллийг дэлгэрүүлэх	Аж ахуйн нэгжийн үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний зах зээлд оролцогчид, хөрөнгө оруулагч, үнэт цаасны зах зээлд оролцогчид
-----	--------------------	---	---

Практикаас харахад дээр дурьдсан үүргүүдийн заримыг аж ахуйн удирдагч нар зайлшгүй шаардлагатай (бүтээгдэхүүний үйлдвэрлэл, борлуулалтын) гэж боддог, харин бусад үүргүүдийг нэг их чухал биш хэмээн үздэг. Энэ сүүлчийнх нь танин мэдэхүйн ба сурч боловсрох үүргүүд боловч үйлдвэр, аж ахуйн нэгжийн үйл ажиллагааны ба цаашдын хөгжлийн нэн тэргүүний суурь болох ач холбогдолтой. Танин мэдэхүйн үүргийг дэсдараатай хэрэгжүүлбэл тухайн аж ахуйн нэгжийн хувьд зах зээлийн нөхцөл ба технологийн боломжийг сайн мэдэхгүй бусад субъектүүдийн өмнө өрсөлдөөний онцгой давуу тал олж авах урьдчилсан давамгайл байдлыг бүрдүүлдэг. Энэ нь зардал буурах, зах зээлийг хамрах хүрээ өргөжих, эрэлт хэрэгцээний хэлбэлзлийг урьдчилан тооцох зэргээр илэрдэг. Эцсийн дүнд хэн илүү мэддэг, чаддаг байна тэр субъект л орчин үед зах зээлийн өрсөлдөөнд давуутайгаа харуулна.

Үйлдвэр, аж ахуйн нэгжүүдийн шинэчлэлийн үндсэн чиглэл

Одоо цагт "Сонгодог аж ахуйн нэгж"-ийн тухай гурван үндсэн үзэл баримтлал байдаг. Үүнийг аж ахуйн нэгжийн шинэчлэлийн үйл явцад зайлшгүй анхаарууштай. Нэгдэх нь, одоогийн эрэлт хэрэгцээтэй, төлбөрийн чадвартай бүтээгдэхүүн үйлдвэрлэхэд дээд зэргээр тусгайлан нарийн мэргэшсэн байх. Үйл ажиллагаанд шууд холбогдолгүй илүүдэл зүйлүүдээс чөлөөлөгдсөн, үйлдвэрлэлийн зардал ба ашгаас нэмэгдэл зарлага гаргахыг үнэнхээр хязгаарладаг, нийгмийн үүргийн ачааллыг доод хэмжээнд байлгах, ажилтангуудын ажлын болон технологийн дотоод сахилгыг хатуу чангатгаж, удирдлагын тогтолцоо оновчтой чиглэл зорилготой болгосон байдаг. Ийм үзэл бодол нь "минимализм" гэдэг чиг баримтлалын нэр авдаг.

Ийм аж ахуйн нэгжийн үйл ажиллагаа нь дээд зэргээр стандартчилагдсан байх боловч засвар болон орлуулан солих, зах зээлийн өөрчлөлтийн дагуу уян хатан зохицуулах, шилжүүлэх бололцоогоор хангагдсан байдаг. Нөөцөө дайчлан ашиглах үр ашиг нь өндөр түвшинд байх магадлалтай.

Хоёрдахь нь, өөрийгөө бүхэл бүтэн нөхөн үйлдвэрлэх цогцолбор байх үзэл баримтлал. Туршлага хуримтлуулсны үр дүнд эдийн засаг, санхүүгийн тодорхой чадавхид хүрэх, тэдний дотоод бүрэлдэхүүн хэсгүүдийн хоорондын уялдаа холбоо, цаашдын хөгжил нэг зорилгод чиглэгдэнэ. Давуу тал нь хөрөнгийн урсгал хөдөлгөөн сайтай, хуримтлалаа бүрдүүлж чадсан, нөөцүүд оновчтой зохицуулалттай тэдгээрийг ашиглах үр ашгийн урт хугацааны өндөр үзүүлэлттэй байна.

Гуравдахь нь, аж ахуйн нэгж зөвхөн бүрэн бүтэн ба зорилтод бүхийгээс гадна "сэтгэл урамшил"-ын тогтолцоо юм. Өөрөөр хэлбэл дотоод давтагдашгүй сэтгэл зүйн эхлэлийн үндсийг дээд зэргийн түвшинд эзэмшсэн тогтолцоо мөн.

Аж ахуйн нэгжийн үйл ажиллагаанд идэвхжил, зорилтот чиглэл, зохицолдсон уялдаатай хөгжил нь эндээс эхэлдэг. Аж ахуйн нэгжийн "сэтгэл урамшил"-ын илэрхийлэл нь дотоод хүрээлэн байгаа орчны ая тухтай уур амьсгал, захиалагч ба хамтрагч түншүүдтэй харьцах харилцааны онцлог гадаад хүчин зүйлд хандах хандлага "үйлдвэрлэлийн удирдлагын соёл" гэдэг нэр томъёогоор нэгтгэгдэнэ.

Сэтгэл, урамшил бүхий аж ахуйн нэгжийн зах зээлийн үйл явц нь ажлын ёс зүйг баримтлах, хууль, тогтоомжийг биелүүлэх, хамтрагч түнш, өрсөлдөгчидтэйгээ ёс суртахуунтай харьцах зэргээр тодорхойлогдоно.

Ийм аж ахуйн нэгжийн үйл ажиллагаа нь зах зээлийн бусад субъектүүдийн зан үйлд нөлөөлж, ажил хэрэгч хамтлагын нийт нөхцөл байдлыг сайжруулдаг нийгэм, эдийн засгийн хөгжлийн эерэг ач холбогдолтой.

Аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагааны үр дүнг сайжруулах хамгийн хүсэн хүлээж байгаа болон зөн олны сонголтонд тохирсон чиглэл ба дээд зэргийн "сэтгэл, урамшил"-тай газар байх ёстой гэдгийг үндэс болгож байгаа юм. Ийм төрлийн аж ахуйн нэгжид хамт олны ба удирдлагын хамтран ажиллах шилдэг түвшинд хүрч, шинэ санаа сэдэлтийн хөгжлөөр үйлдвэрлэл, нөхөн үйлдвэрлэл болон маркетингийн үйл явцын хооронд оновчтой харьцаа тогтоодог. Дараах зураг дээр аж ахуйн нэгжийн аж ахуйн гурван үйл явц-үйлдвэрлэл, борлуулалт, нөхөн үйлдвэрлэл ба шинэ санаа сэдэлтийн гурван үйл явцын нэгдлийг харууллаа (тод сумаар үйлдвэрлэл-нөхөн үйлдвэрлэлийн дүрсийг, нарийн сумаар шинэ санаа сэдэлтийн дүрсийг харууллаа).



Ийм үйлдвэр, аж ахуйн нэгж:

- хувь нийлүүлэгчдийн хувьцааны борлуулалт, ноогдол ашгийн хүлээлтийн ашиг сонирхол их байдаг;
- нийгэм, экологи ба эдийн засгийн талаар улс нийтийн хүсэмжинд мэдрэмтгий, өөрийн үйл ажиллагааны үр дагаврын ёс суртахууны хариуцлага мэдэрч байдаг.

Зах зээлтэй зохицон хөгжиж, зохицон харилцан үйлчилж байгаа аж ахуйн нэгжүүдийг эдийн засгийн шинэчлэлийн хөдөлгөөнд илүү товойлгон тавьж, улмаар тэдний дотоод амьдралын хэв зүй, хоорондын харилцааг эрс өөрчлөхийг шаарддаг. Үүний тулд аж ахуйн нэгжийн өөрсдийнх нь хүчин чармайлт хүрэлцэхгүй, иймээс нийгэм, төр, аж ахуйн субъектүүд үйл ажиллагааг зохицуулсан программ, тодорхой дэмжлэг зайлшгүй хэрэгтэй.

Аж ахуйн нэгжийн шинэчлэх үндсэн чиглэлд дараах өөрчлөлтийг тусгавал зохистой:

- аж ахуйн нэгжийн дотоод зохион байгуулалт-ажил үүргийн бүтэц, тэдний үйлдвэрлэл, нөхөн үйлдвэрлэл, маркетинг, шинэ санаа сэдэлтийн идэвхжил хоорондын оновчтой харилцааг бүрдүүлэх;
- аж ахуйн нэгжийн удирдлагын тогтолцоо шийдвэр гаргах тогтолцоо, үүний дотор том хувь нийлүүлэгчтэй (гаргасан шийдвэрийнхээ талаар хариуцлага өндөржүүлэх), жижиг хувь нийлүүлэгчтэй (шийдвэр гаргахад оролцох эрхийг хангах) харьцах харилцаа;
- салбарын хэмжээнд аж ахуйн нэгжүүдийн хоорондын хамтын ажиллагаа ба зохицуулалт;
- нийгмийн зүгээс аж ахуйн нэгжийн үйл ажиллагаанд, аж ахуйн нэгж төрийн үйл ажиллагаанд нөлөөлөх суваг;
- хөрөнгийн зах зээл, аж ахуйн нэгжийн харьцах харилцааг шинэчлэх;
- аж ахуйн нэгжийг бүртгэх, татан буулгах тогтолцоо;
- улс орны бүхэл эдийн засгийн төлөвлөлт, прогнозчиллын тогтолцоотой аж ахуйн нэгжийн үйл ажиллагааны дотоод төлөвлөлтийн харилцан уялдааны тогтолцоо.

Эн тэргүүнд анхаарал хандуулах арга хэмжээнд дараах зүйлүүд орно:

- Компани, нөхөрлөлийн хоорондын дундын хэлбэрийн тусламжтайгаар аж ахуйн нэгжийн ажлын үр дүнгээр удирдлага ба эд хөрөнгийн хувьд өмчлөгчийн хүлээх хариуцлагыг өндөржүүлэх талаар аж ахуйн нэгжийн зохион байгуулалт-эрх зүйн хүрээг өргөтгөх;
- Аж ахуйн нэгжийн удирдлагад ерөнхий захирал, менежерүүд, ажиллагсад, том жижиг хувь нийлүүлэгчдийн хооронд хүчний тэнцвэр (эрх, хариуцлага)-ийг болон удирдлагын ардчиллыг хангах чиглэлийг компанийн хуулинд тодорхой зааж өгвөл зохистой.
- Аж ахуйн нэгж бүрийн үйл ажиллагаанд бизнес, санхүүгийн болон стратегийн төлөвлөлтийг бүрэн нэвтрүүлэх, төлөвлөгөөт стратегийн мэдээллийг солилцох, зөвшилцөх талаар олон түвшний оновчтой тогтолцоо бий болгох;
- Аж ахуйн нэгжүүдэд одоогийн байдлаар хөдөлмөрийн хуулийн биелэлт ерөнхийдөө хангалтгүй байгаа үүнтэй уялдаж

- ажиллагсадыг аттестатчилах, хөдөлмөрийн хөлс төлөх, албан тушаалын хөдөлгөөний тогтолцоог боловсронгуй болгох;
- Аж ахуйн нэгжийн үйл ажиллагааны онцлогтой уялдуулан шинэ санаа сэдэлт-нөхөн үйлдвэрлэлийн бүтцийг шинээр боловсруулж хэрэгжүүлэх. Энэ нэн чухал.
 - Аж ахуйн нэгжийн үнэт цаас зах зээлд оролцох үйл ажиллагааг өргөтгөх, идэвхжүүлэх.
 - Эдийн засгийн салбарын бүтцийг сэргээж, мэдээлэл солилцоо, үйл ажиллагааны зохицуулалтын салбарын босоо бүтцийг бий болгох, нэг салбарын аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагааны нөхцлийн орон нутгийн ялгааг зөөлрүүлэх, арилгах талаар бодож үзүүштэй байна.